

## ТАНИЛЦУУЛГА

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл  
авах эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт  
оруулах хуулийн төслийн тухай

Дэлхий дахинд мэдээлэл, түүнд хийгдэж буй олборлолт, шинжилгээний ажлын үнэлэмж, үнэ цэнэ өдөр ирэх тусам үлэмж ихээр нэмэгдэж байна. Хэдхэн жилийн өмнө хатуу дэд бүтцийг эзэмшигч компани, бизнес, төр хамгийн хүчтэй гэгдэж байсан бол өнөө цаг мэдээллийг олж чаддаг, олсон мэдээлэлдээ зөв үнэлэлт, дүгнэлт хийж чаддаг төр, бизнесийг хамгийн хүчтэй гэж томъёолох болжээ. Иймээс ч дараагийн “газрын тос” бол мэдээлэл юм гэж дуу нэгтэйгээр хүлээн зөвшөөрч байна.

Энэ чиг хандлагаас Монголын төр, Улсын Их Хурал, Засгийн Газар аль болох хоцрохгүйг хичээн ажилласаар байна. 2020-2024 оны Улсын Их Хурал анх удаа өөрийн бүтэцдээ Инноваци, цахим бодлогын байнгын хороог байгуулж, төр дээрээс доош хүртэлх бүхий л шатандаа дижиталчлал, цахим шилжилтийг урамшуулан өөрийн тэргүүлэх чиглэлийн нэг гэж үзэж байгаа нь тун сайшаалтай. Түүнчлэн сүүлийн жилүүдэд залуучуудын дунд дата, өгөгдөл дээр тулгуурласан бизнес эрхлэх сонирхол ихээхэн нэмэгдэж, төрд хуримтлагдаж буй харилцагчийн хувийн мэдээлэл ХУР, ДАН системийн өгөгдөлд үндэслэн зээл олгох мэт үйлчилгээ, бизнесүүд ихээхэн нэмэгдэж байна. Энэ төрлийн бизнес эрхлэгч компаниуд эхнээсээ дотоодын зах зээлд хөрөнгө босгоод зогсохгүй, гадагшаа гарч олон улсаас хөрөнгө мөнгө босгож, дэлхийд өрсөлдөхөөр тэмүүлцгээж байна.

Гэвч ХУР, ДАН мэт шиг хувийн өндөр түвшний мэдээлэл үл шаардах бөгөөд статистик мэдээллээс илүү боловсруулагдсан зарим төрлийн мэдээллийг төрд үүсэн буй өгөгдлийг ашиглан борлуулж улсын төсөвт шинэ орлогын эх үүсвэр бий болгох, мэдээллийг ашиглагч бизнесүүд, старатуудад өгөгдөл олборлолт, шинжилгээ хийх түүхий эдийг бий болгох хэн хэн нь цугтаа хожих шийдлийг бүрдүүлэх боломжийг бүрдүүлэхээр уг хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачилж байгаа болно.

Төрийн дэд бүтцийг ашиглан бий болж буй цахим татварын систем Ebarimt дээр үүсч буй бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээрх өгөгдөл болон төрийн үйлчилгээ болох улсын бүртгэл дээр үүсч буй эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл, гаалийн байгууллагууд дээр үүсэн хуримтлагдаж буй бүтээгдэхүүнүүдийн нарийвчилсан импорт, экспортын мэдээлэл гэх мэт бизнесүүдэд өдөр тутам шаардлагатай, боловсруулалт, үр дүнгээс нь өндөр өгөөж хүртэж болохуйц өгөгдлүүдийг өнөөг хүртэл нээлттэй болгоогүй байна. Эдгээр өгөгдлийг нээснээр бизнес эрхлэгчид, тэр тусмаа шинээр бизнес эхлүүлэхээр зорьж

буй старатуудын хөрөнгө оруулалтын өгөөж нэмэгдэх, бүтээмж сайжрах боломжууд бүрдэнэ. Ийм үнэ цэнэтэй, өгөөжтэй мэдээллийг ил болгож, бизнес эрхлэгчид, өгөгдөл тоон мэдээлэл дээр ажиллагчид бэлэн нөөц, олборлох түүхий эдтэй болж буй тул үүнийг шууд зардлаас нь өндрөөр үнэлэн борлуулах боломжтой болно. Ингэснээр төсөвт орлогын шинэ боломж бий болно гэж үзэж байна.

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль 2011 онд батлагдсан. Түүнээс хойш уг хуулийн зарим хэсгийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлсон “Шилэн дансны тухай” хуулийг мөн шинээр батлан мөрдүүлсэн байдаг. Эдгээр хуулиуд нь иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг сайтар тодорхойлж өгсөн боловч хэрэгжилтийн үр дүн нь төдийлөн хангалттай биш байгааг Хараат бус судалгааны хүрээлэн, Глоб интернейшнл зэрэг судалгааны байгууллагуудын үнэлгээгээр уг хуулийн хэрэгжилтийг хангалттай бус байгаа тухай дурдсан байдаг.

Уг нэмэлтээр иргэд, бизнесүүдэд нэн шаардлагатай байгаа, боловсруулалт дүн шинжилгээ хийж чадвал үр дүн, үнэ цэнээ өгөх НӨАТУС дээр үүсэн хуримтлагдаж буй барааны бүлэг, бүтээгдэхүүний нэр төрлийн борлуулалтын мэдээлэл, улсын бүртгэлийн эд хөрөнгийн бүртгэл дээр үүсч буй үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын мэдээлэл тэргүүтэй мэдээллийг ашиглах боломжийг бүрдүүлэх, түүнийг шинэчлэх, үнэлгээг тогтоох тухай зохицуулалтыг шинээр тусгалаа. Хуулийн төсөл батлагдснаар бизнесүүдийн хөрөнгө оруулалтын үр ашиг нэмэгдэж өрсөлдөх чадвар сайжрах, өгөгдөл мэдээлэл дээр ажилладаг шинэ бизнесийн төрлүүд нэмэгдэх боломжууд бий болно гэж үзэж байна.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Статистикийн тухай хууль, Төв банкны тухай хууль, Гаалийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуулиудыг судлан үзсэн бөгөөд дээрх зохицуулалтыг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд тусган өгөх нь илүү оновчтой гэж үзсэн болно. Уг хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийн хамтаар Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийг төслийг мөн боловсруулан хамт өргөн барив.

Олон нийтийн саналыг авахаар 2020 оны 12 сарын 9-ны өдрөөс эхлүүлэн [parliament.mn](http://parliament.mn) сайтад хуулийн төслийг холбогдох материалын хамт байршуулан бөгөөд санал ирээгүй болно.